

ОРХОН АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛИЙН СУДАЛГАА, ҮР ДҮН

Э.Баттуяа*, А.Батдаваа**

Хураангуй: Хөдөө аж ахуйн салбар нь манай орны уламжлалт салбар бөгөөд 2021 оны байдлаар Хөдөө аж ахуйн салбар (Үндэсний статистикийн хороо, 2023) Дотоодын нийт бүтээгдэхүүний 13 хувийг эзэлж байгаа бол экспортын орлогын 6 хувь, ажиллах хүчний 26 хувь тус салбарт хамаарч байна. Харин Үндэсний статистикийн хорооны мэдээллээр, Дотоодын нийт бүтээгдэхүүн 2022 оны эхний есөн сард 3.7 хувиар өссөний 1.6 хувийг хөдөө аж ахуйн салбарын өсөлт эзэлж байна. Сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйг (Хүнс, хөдөө аж ахуйн яам, 2023) эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэх, хөдөө аж ахуйг байгалийн аливаа эрсдэлээс хамгаалах, хөдөөд хүмүүс тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг улам бүр сайжруулахад төрөөс маш их дэмжлэг тусалцаа үзүүлж байна.

Түлхүүр үгс: Хөдөө Аж Ахуйн салбар, Үндэсний Статистикийн Хороо, газар тариалан, газар тариалангийн салбарын хүчин зүйлийн шинжилгээ

ANALYSIS AND RESULTS OF FACTORS INFLUENCING THE AGRICULTURAL SECTOR IN THE REGION

Abstract: Summary The agricultural sector is considered the traditional sector of the nation, as of 2021, the agricultural sector comprises 13% of the GDP, 6% of the export income, 26% of the labor force. According to the national statistics committee, of the 3.7% increase in GDP for the first month of the year 2020, 1.6% is comprised of agricultural contribution. In recent years, the government has provided a considerable support and assistance to the intensive development of agriculture, to ensure the growth of production, to increase efficiency, to improve the quality and safety of food products, to protect agriculture from any natural hazards, and to further improve the conditions for people to work and live comfortably in rural areas.

Keywords: Agricultural industry, National statistics committee, agriculture, factor analysis of the agricultural sector

* Эрдэнэт Цогцолбор Дээд Сургууль, (E-mail) battuya@erdenetis.edu.mn

** Эрдэнэт Цогцолбор Дээд Сургууль, (E-mail) batdavaa@erdenetis.edu.mn

Судалгааны зорилго

Орхон аймгийн газар тариалангийн салбарт нөлөөлж буй хүчин зүйлсийг асуулгын аргаар үнэлэхэд судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны зорилт

- ✓ Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй газар тариалангийн компани, өрхийн тариалан эрхэлж буй төмс, хүнсний ногоо тариалдаг иргэд, тэжээлийн ургамал тариалдаг аж ахуй нэгж иргэдээс түүвэр судалгаа авч, судалгааны үр дүнг нэгтгэх,
- ✓ Орхон аймгийн хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлд нөлөөлж буй хүчин зүйлсийн хамаарлыг тооцох

Судалгааны хэсэг

Бид энэхүү судалгааг тоон судалгааны аргаар хийсэн бөгөөд эх олонлогийн онцлогоос хамаарч давхаргат, пропорциональ санамсаргүй түүврийн аргыг ашиглав. Түүврийн эх олонлогоор Үндэсний Статистикийн Хорооны албан ёсны мэдээллийн сангаас Орхон аймгийн газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, өрхийн тоог авч түүврийн оновчтой хэмжээг дараах байдлаар тооцоолов.

Зураг 1. Түүврийн оновчтой хэмжээг тооцсон байдал

Determine Sample Size

Confidence Level: 95% 99%

Confidence Interval:

Population:

Sample size needed:

2021 оны байдлаар Орхон аймгийн газар тариалангийн бүс болох Жаргалант сумын Улаантолгой, Жаргалант багууд, Баян-Өндөр сумын Баянцагаан, Дэнж, Эрдэнэ, Говил багуудыг хамруулсан газар тариалан эрхлэгчид 462 өрх, үр тариа эрхлэгч 14 аж ахуй нэгж түүврийн эх олонлог болж байна. Зурагт үзүүлсэн тооцооллын үр дүнд түүврийн хамгийн бага оновчтой хэмжээг 95%-ийн итгэх магадлалтай, $\pm 5\%$ -ийн алдааны хязгаартай байхаар тооцож, 154

тариаланчдыг судалгаанд хамрууллаа.

Судалгааны асуулгыг Орхон аймгийн ХАА-н газар, газар тариалангийн үйлдвэрлэл, техник технологи, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, хүлэмжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс санал авч боловсруулсан. Хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй тариаланчдад тулгамдаж буй асуудал болон эерэг, сөрөг нөлөө үзүүлэгч хүчин зүйлүүдийг үнэлүүлэх хэсгүүдээс бүрдсэн асуулгын хуудсыг ашиглалаа. Асуулгын чанар, логик уялдаа, хариултын боломжит байдлыг шалгах, судалгаанд оролцогчдын бэлэн байдлыг тандах зорилгоор туршилтын судалгааг судалгааны 11 мэдээлэл цуглуулагч 2022 оны 10-р сарын 02-ний өдөр явуулав. Туршилтын судалгаанд Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг үр тарианы 2 компани, төмс хүнсний ногоо тариалдаг 5 иргэн, 8 малчин иргэд нийт 15 хүнийг хүнийг хамруулсан бөгөөд тус судалгааны үр дүнгээр анкетаа сайжруулсан.

Судалгааны найдвартай байдлыг шалгадаг статистик арга зүй нь Кронбах альфа (Мартинес, 2014) коэффициент байдаг. Энэ нь $0 \leq x \leq 1$ хооронд утгаа авах ба $0.7 \leq x$ байх нь ач холбогдолтой буюу судалгааны асуултуудын найдвартай байдлыг илэрхийлдэг. Мөн энэхүү коэффициентоор хэмжээс нь э оновчтой эсэхийг тодорхойлж болдог. Доорх хүснэгт нь Кронбах альфа коэффициент нь хангалттай сайн байгааг илтгэж байна.

Анкетын асуулга үндсэн 2 хэсгээс бүрдэнэ.

А. Тариалан эрхлэгчийн ерөнхий мэдээлэл

Б. Газар тариалан эрхлэгчдэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох асуулга

Судалгааны найдвартай байдлыг шалгахад зорилгоор SPSS программ (Б.Энх-Амгалан, 2018 он) дээр Кронбах альфа коэффициент тооцоход судалгаанд оролцогчдын хариултууд нийцэл “сайн” гэж үнэлэгдсэн тул анкетын аргаар цуглуулсан мэдээллийг судалгаанд ашиглах бүрэн боломжтой гэж үзсэн.

Хүснэгт 1. Найдвартай байдлын үнэлгээ

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
0.913	0.914	26

Газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, өрхийн шинж байдал

Судалгаанд Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулдаг хөдөлмөрийн насны 18-аас дээш насны газар тариалан төмс хүнсний ногоо тэжээлийн ургамал тариалдаг 154 иргэд хамрагдсан бөгөөд нас, хүйс, ажиллах хүчний нөөц, үйл ажиллагааны хэлбэр, ажлын туршлага, үйл ажиллагааны чиглэл, зэрэг үзүүлэлтүүдийн ерөнхий төлөв байдлыг энэ хэсэгт авч үзэх болно.

Судалгаанд хамрагдсан иргэдийг насны байдлаар нь ангилбал 6.5% нь 22-30 насныхан, 23.4% нь 31-40 насныхан, 28.6% нь 41-50 насныхан 41.6% нь 51-дээш насныхан эзэлсэн байна. ХАА-н салбарт ажиллахад нас төдийлөн харгалздаггүй бөгөөд тэтгэвэрт гарсан ч өрхийн хүрээнд эрхэлж болдог нь судалгаанаас харагдаж байна. Өөрөө хэлбэл, судалгаанд хамрагдсан иргэдийн 41.6% нь 51 дээш насныхан эзэлсэн байна.

Хамгийн цөөн буюу 6.5% нь 22-30 насныхан байгаа нь энэ салбарт залуучууд төдийлөн ажиллах сонирхолгүй, идэвх бага байгааг илтгэж байна.


Газар тариалангийн салбарын төрөлд төмс, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхлэгч, жимс жимсгэнэ тариалалтын хүрээнд эмэгтэйчүүд давамгайлдаг тул эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр буюу 61%, эрэгтэй 39%-ийг эзэлж байна. Иргэн, аж ахуй нэгж байгууллагаас ажиллах хүчний нөөцийг тодруулахад 64.9% нь 1-5 хүртэлх ажиллагсадтай, 22,1% нь 6-10 ажиллагсадтай, 13% нь 11-дээш ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна. Газар тариалангийн салбарт аж ахуй эрхлэгчдийн 64.9% нь 1-5 хүртэлх ажиллах хүчинтэй байгаа нь өрхийн болон жижиг бизнесийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг нь харагдаж байна.

Аж ахуй эрхлэлтийн төрөл хэлбэрээр ангилан харуулбал, 92.2% нь хувь иргэн, 3.9% нь хоршоо, 3.9% нь компанийн төлөөлөл судалгаанд хамрагдсан байна. Судалгаанд төмс, хүнсний ногоо тариалагч хувь иргэд 92.2% буюу хамгийн олон байна. Орхон аймгийн хэмжээнд статистикийн мэдээнд тариалан эрхэлдэг өрхийн тоо 462 байдгаас судалгаанд 154 өрх хамрагдсан нь энэ үзүүлэлтийн хувь өндөр гарсантай шууд холбоотой юм. Орхон аймгийн хэмжээнд үр тарианы 14 компани үйл ажиллагаа явуулдаг судалгаанд 10 компани, 2 хоршоолол хамрагдсан нь судалгааны үр дүнг бодитой байгааг илтгэж байна.

Газар тариалангийн салбарт үйл ажиллагаа явуулж буй туршлагыг харвал 19.5% нь 0-5 жил ажилласан, 19.5% нь 6-10 жил ажилласан, 5.2% нь 11-15 жил, 55.8% нь 15-аас дээш жил ажилласан туршлагатай байна. Орхон аймгийн тариалалтын бүс болох Жаргалант сум нь 1976 онд анх төмс, хүнсний


ногооны зориулалтаар байгуулагдсан нь тариаланчдын үе дамжсан туршлага одоо ч байсаар байгааг 55.8% нь буюу 15- дээш жилийн туршлагатай гэсэн үзүүлэлт харуулж байна.

Зураг 2. Судалгаанд хамрагдсан аж ахуй эрхлэгчдийн туршлага



Газар тариалан эрхлэгчдийн тариалсан ургацыг ургамлын төрлөөр нь авч үзвэл, давхардсан тоогоор 2.6 % нь үр тариа, 64.9% нь төмс, 90.9% нь хүнсний ногоо, 5.19% нь таримал тэжээл, 3.9% нь техникийн ургамал, 2.6% нь жимс жимсгэнэ тариалдаг гэж хариулсан ба 90.9% нь төмс, хүнсний ногоо тариалагчид хамгийн өндөр үзүүлэлттэй харагдаж байна. Энэ нь Жаргалант сумын нийт өрхийн 20% төмс хүнсний ногоо тариалдагтай шууд холбоотой юм. Хамгийн бага нь 2.6% нь жимс жимсгэнийн аж ахуй эрхлэгч байна.

Зураг 3. Судалгаанд хамрагдсан тариалан эрхлэгчдийн төрөл, ангилал



Газар тариалангийн салбарт нөлөөлөх хүчин зүйлд өгөх үнэлгээ

Асуулга судалгааны хүрээнд газар тариалангийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй иргэн аж ахуй нэгжүүдээс газар тариалангийн салбарт нөлөөлөгч хүчин зүйлийн үнэлгээг, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хүчин зүйл, дотоод нөөц боломж, оролдогч талуудын нөлөө гэсэн 5 бүлэг 28 асуулгаар хүчин зүйлийн нөлөөллийн үнэлгээг тодорхойллоо.


Нөлөөлөх үнэлгээг хүчин зүйл тус бүрээр сонгон авч 1-5 оноогоор үнэлэв. Хүчин зүйлийн нийлбэр оноо нь

- 1-1.79 маш муу,
- 1.8-2.59 муу,
- 2.6-3.39 дунд зэрэг,
- 3.4-4.1 сайн,
- 4.2-5.0 маш сайн нөлөөтэй гэж үзнэ.

Газар тариалангийн салбарт нөлөөлөгч хүчин зүйлийг дараалалд оруулан үнэлбэл.

1. “Оролдогч талуудын нөлөө” -1.9 оноо,
2. “Эдийн засгийн хүчин зүйлийн нөлөө” -2.2 оноо
3. “Дотоод нөөц боломж” -2.3 оноо
4. “Нийгмийн хүчин зүйлийн нөлөө” -2.43 оноо
5. “Байгаль орчны нөлөө” -2.5 оноо тус тус авсан байна

Зураг 4. Газар тариалангийн салбарт нөлөөлөгч хүчин зүйлс



“Маш муу” үнэлгээтэй нь оролдогч талуудын нөлөө бүлэг (1.9) : Орхон аймгийн газар тариалангийн салбарын оролдогч талууд болох засгийн газар холбогдох яам, орон нутгийн засаг захиргааны байгууллагын дэмжлэг


төсөл хөтөлбөр, ОУ-ын болон төрийн бус байгууллагууд, банк санхүүгийн байгууллага, ХАА-н тоног төхөөрөмж түрээслэгч, борлуулагч аж ахуй нэгж, ХАА-н анхдагч түүхий эд ашиглагч байгууллагууд болон газар тариалангийн аж ахуй эрхлэгчдийн хамтын ажиллагаа, оролцоо муу байгааг судалгааны үр дүн харуулж байна.

“Муу” үнэлгээтэй нь байгаль орчны нөлөө бүлэг (2.5) : Орхон аймгийн газар тариалан эрхлэгчдэд байгаль, цаг уурын нөлөөлөл, хөрсний элэгдэл, дэлхийн дулаарал, ургамал хамгааллын бодисын зохисгүй хэрэглээ, цагаан тоосны дэгдэлт, хор уршиг өнөөгийн байдалд муу гэсэн үзүүлэлтэй байгаа боловч бусад 4 -н хүчин зүйлсээс Лайкерт шкалын аргын үнэлгээ нь өндөр байгаа нь тариалан эрхлэгчдэд сөрөг нөлөөлөл нь харьцангуй бага гэж үзэж байна.

Үзцлэлт бүрийн үнэлгээ

- ✓ Судалгаанд оролцогчид газар тариалангийн салбарт нөлөөлөгч 28 үзүүлэлтийг тус бүрээр нь үнэлсэн байдлаас “Олон улсын болон төрийн бус байгууллагуудын оролцоо дэмжлэг” гэсэн хүчин зүйл нь маш муу үнэлгээтэй гарсан нь газар тариалангийн салбарт төрийн бус байгууллагуудын оролцоо дэмжлэг хүрдэггүй газар тариалангийн салбарт Монголын тариаланчдын үндэсний холбоо, Монголын хүнсний ногоочдын холбоо зэрэг байгууллагууд байдаг ч тэдний оролцоо аймгийн тариаланчдад тэр бүр хүрдэггүй гэж үзэж байна. Мөн төрөөс хөдөө аж ахуйг дэмжих зорилгоор маш олон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа боловч тэр хөрөнгө оруулалт, санхүүжилт нь яг жинхэнэ эзэндээ хүрч үйлчилж байна уу гэдэг нь эргэлзээтэй байна.
- ✓ Орхон аймгийн газар тариалангийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд нөлөөлөх 28 хүчин зүйлээс 23 хүчин зүйлд нь судалгаанд хамрагдсан иргэд аж ахуй нэгжийн төлөөлөл муу үнэлгээ өгсөн байна.

Зураг 5. Газар тариалангийн салбарт нөлөөлөгч хүчин зүйлс, ангилал



- ✓ Хүчин зүйлсийн үнэлэх шинжилгээнд газар тариалангийн салбарын аж ахуй эрхлэгчдэд байгаль, цаг уурын нөлөөлөл (цочир хүйтрэлт, ган, мөндөр) Дэлхийн дулаарал, Ургамал хамгааллын бодисын зохисгүй хэрэглээ, Дундын борлуулагчдын (ченжүүд) оролцоо, нөлөө гэсэн хүчин зүйлүүд Лайкертын үнэлгээгээр дунд буюу салбарт төдийлөн сөргөөр нөлөөлөхгүй ч эерэг нөлөө үзүүлээгүй гэж тооцно.

Зураг 6. Газар тариалангийн салбарт нөлөө үзүүлсэн хүчин зүйлс



- ✓ Үнэлгээний 28 үзүүлэлтийн үр дүнд “Сайн” болон “Маш сайн” үнэлгээтэй хүчин зүйл гараагүй тул өнөөгийн газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн аж ахуй нэгжид өндөр ач холбогдол бүхий хүчин зүйл байхгүй байна.

Газар тариалангийн салбарын хүчин зүйлийн шинжилгээ

Хүчин зүйлүүдийн нөлөөллийн хүчийг тогтоох зорилгоор корреляцийн шинжилгээг хийсэн бөгөөд газар тариалангийн салбарт нөлөөлөх 28 хүчин зүйлсийг хамруулсан уг үзүүлэлтэд эерэг хүчтэй нөлөөлсөн 5 хүчин зүйл, сөргөөр нөлөөлсөн 6 хүчин зүйл байна

Орхон аймгийн газар тариалан эрхлэгчдэд эергээр нөлөөлөх 5 хүчин зүйлд усалгаа, усалгааны системийн байдал, эрдэс бордооны хангамж хүрэлцээ, чанарын шаардлага хангасан үр тарианы олдоц нийлүүлэлт, бүтээгдэхүүн борлуулах цэг салбарын хүрэлцээ орон нутгийн засаг захиргааны байгууллагын дэмжлэг төсөл хөтөлбөр зэрэг үзүүлэлтүүдэд салбарын иргэн аж ахуй нэгжид эергээр нөлөөлж болох үзүүлэлт болсон байна.

Улс, аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар “Хүнсний ногоо үндэсний хөтөлбөр”, “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр, 10-н их наядын зээлийн хөтөлбөр, “Өрхийн тариалалтыг дэмжих” хөтөлбөр, “Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ үндэсний хөтөлбөр” “Жаргалантын ногоочид” дэд хөтөлбөрүүд аймгийн тариалан эрхлэгчдэд үр дүнгээ өгсөнтэй холбоотой байна.

“Өрхийн тариалалтыг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногооны үрийг аймгийн ногоочдод 80% хөнгөлөлтэй үнээр өгч байгаа нь тэднийг үйл ажиллагаанд томоохон дэмжлэг болж чадсан байна. Мөн Жаргалант сумын ногоочдод хөтөлбөрийн хүрээнд усалгааны иж бүрдэл болох усны мотопомп, намираа шланг, холбох хэрэгсэл бүхий 10 бүрдэл тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Аймгийн хэмжээнд инженерийн хийцтэй 144, энгийн 97, нийт 241 худаг, уст цэг ажиллаж байна.

Зураг 7. Газар тариалангийн салбарт эерэг нөлөө үзүүлсэн хүчин зүйл




Газар тариалангийн салбарт аж ахуй эрхлэгчдэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлд инфляцийн нөлөө, шатахууны үнийн өсөлт, тариалалтын талбайн хэмжээ, хүрэлцээ цагаан тоосны дэгдэлт, хор уршиг, дэлхийн дулаарал, байгаль, цаг

уурын нөлөөлөл (цочир хүйтрэлт, ган, мөндөр) зэрэг хүчин зүйлүүд шууд сөрөг нөлөө үзүүлсэн байна. Сөрөг нөлөө үзүүлэгч хүчин зүйлүүдээс цагаан тоосны дэгдэлт хамгийн өндөр буюу 32%-ийг эзэлж байгаа Орхон аймгийн хувьд энэ нь маш том анхаарал татсан асуудал болоод байна. Цагаан тоос нь ганцхан газар тариаланд бус мал аж ахуй, хүний эрүүл мэндэд ч хор хөнөөлөө учруулаад байна. Байгаль цаг уурын нөлөөлөл нь 21%-ийг эзэлж байна. Энэ нь тариаланч аж ахуй нэгж, иргэд өөрсдөөс нь шалтгаалах хүчин зүйл юм. Эрсдэлийг тооцоолж бизнесийн үйл ажиллагаандаа гадаад орчноос нөлөөлөх хүчин зүйлийн нөлөөллийг маш сайн тооцоолж, хариу үйлдлийг төлөвлөгөөтэй, бодлоготой ажиллах нь үр дүнтэй юм.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд шатахуун, дизель түлшний үнэ өссөн нь үр тариа, малын тэжээл тариалалт, төмс, хүнсний ногооны хураалтын зардал өссөн нь цаашид тогтвортой үйл ажиллагаа эрхлэхэд сөргөөр нөлөөлж байна. Орхон аймаг ХАА-н эдэлбэр газар бага, тариалалт хийх талбайн хүрэлцээ муутай үйлдвэрлэлээ өргөжүүлэх ургацын хэмжээг нэмэгдүүлэхэд хамгийн их саад тогтор болдог байна.

Инфляц нь төв банкны зорилтот түвшин болох 6 ± 2 хувийн интервалыг давж, улсын хэмжээнд 14.4 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 15.2 хувьд хүрч өсөөд байна. Энэ нь газар тариалан эрхэлж буй иргэд аж ахуй нэгжүүдэд шатахууны үнэ, импортоор авдаг хөдөө аж ахуйн сэлбэг хэрэгслийн, хор бордооны үнийн өсөлт нь зардлын өсөлтийг бий болгосон

Зураг 8. Газар тариалангийн салбарт сөрөг нөлөө үзүүлсэн хүчин зүйл



Дүгнэлт

Орхон аймгийн газар тариалангийн салбарт аж ахуй эрхэлдэг 18-аас дээш насны 154 иргэнийг хамруулсан ба олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ. Судалгаанд оролцогчид

нь газар тариалангийн салбарт аж ахуй эрхэлдэг, өнөөгийн бодит байдал, тулгамдаж буй бэрхшээл, онцлог давуу талын талаар өргөн мэдлэгтэй үнэлгээ өгөх чадамжтай иргэд оролцсон. Судалгааны асуулгын найдвартай байдал нь хангалттай сайн (0.951) байгаа нь тооцоолоор батлагдсан.

Судалгааны үр дүнг үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ.

- ХАА-н салбар нь нас, боловсрол, мэргэжил харгалздаггүй онцлогтой, судалгаанд хамрагдсан иргэдийн 41.6% дээш хувь нь 51 дээш насныхан байгаа нь тэтгэвэрт гарсан ч энэ салбарт ажиллах боломжтой.
- Энэ салбарын аж ахуй эрхлэгчдийг хүйсийн хувьд нь аваад үзвэл эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээс 1,5 дахин их байгаа нь төмс, хүний ногоо, жимс, жимсгэнэ, хүлэмжийн аж ахуй эрхлэх зэрэг эмэгтэйчүүд түлхүү ажилладаг нь харагдаж байна.
- Нийт судалгаанд оролцогчдын 64.9% нь (1-5) хүртэлх ажиллах хүчинтэй байгаа нь өрхийн гэр бүлийн хүрээнд аж ахуйг эрхлэх хандлага давамгайлж байна. Газар тариалангийн салбар нь улирлын чанартай, ажиллагсад нь түр ажилтан эсвэл өрхийн гишүүдийн оролцоо дэмжлэгээр үйл ажиллагаа явагддаг байна.
- Газар тариалангийн салбарт аж ахуй эрхлэгчдийн 64.9% нь 1-5 хүртэлх ажиллах хүчинтэй байгаа нь өрхийн болон жижиг бизнесийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг нь харагдаж байна.
- Орхон аймгийн статистик мэдээгээр тариалан эрхэлдэг 462 өрхийн тоо 154 иргэний төлөөллийг, үр тарианы 14 компаниа 10 аж ахуй нэгжийн төлөөллийг судалгаанд хамруулсан. Энэ нь салбарт үйл ажиллагаа явуулдаг бүх оролцогчдыг хамарсан байна.
- Судалгаанд оролцогчдын аж ахуй эрхэлсэн туршлагаас үзэхэд 55.8% нь 15-дээш жил ажилласан байгаа нь Орхон аймгийн тариалангийн өлгий нутаг Жаргалантын САА-н ногоочин, тариаланчдын удам залгамж халаа цөөнгүй байдагтай холбоотой.
- Иргэд өрхийн тариалалтын хүрээнд төмс, хүнсний ногоо хүлэмжийн ногооны тариалалт хийдэг бол үр тариа, тэжээлийн ургамлын аж ахуйг ихэвчлэн компаниуд эрхэлдэг жишиг байна. Судалгаанд давхардсан тоогоор 90.9% нь төмс, хүнсний ногоо, 64.9% нь төмс тариалагч өрх хамрагдсан бол 2.6 % нь үр тарианы компаниуд байна.
- Газар тариалангийн салбарт нөлөөлөгч 28 хүчин зүйлсийг судалгаанд оролцогчдоор Лайкерт шкалын аргаар үнэлсэн бөгөөд “Олон улсын болон төрийн бус байгууллагуудын оролцоо дэмжлэг” гэсэн хүчин зүйл нь тариаланчдаас маш муу үнэлгээ авсан нь ХАА-н салбарт үйл

ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд тариаланч ногоочдод өгөөжгүй байдаг нь судалгаанаас харагдаж байна.

- Лайкерт шкалын үнэлгээгээр 2.64-2.95 оноо буюу дунд үнэлгээтэй 4 хүчин зүйлс байгаагаас “Дундын борлуулагчдын (ченжүүд) оролцоо” хүчин зүйл нь тариалан эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгч болон үйлдвэрлэгчид нийлүүлдэг үнэ цэнтэй оролцогчид гэж үзсэн. Байгаль цаг уур, дэлхийн дулаарлын нөлөө тариалан эрхлэгчдэд өнөөдрийн байдлаар үйл ажиллагаанд нь төдийлөн сөрөг хүчтэй нөлөө үзүүлээгүй байна.
- Ургац өндөр авах тариалалтын технологийг норм дүрмийн дагуу ургамал хамгааллын бодисын хэрэглээний зохистой байдлыг үнэлүүлэх тариаланчид ургамлын хор бордооны ач холбогдлыг сайтар ойлгож ашиглаж байгаа нь судалгаанаас харагдлаа.
- Нөлөөллийн хүчийг тогтоох зорилгоор корреляцийн шинжилгээгээр сөрөг нөлөө бүхий хүчин зүйлд МУ-ын эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж буй шатахууны үнийн хэт өсөлт, инфляцын өсөлт орсон бөгөөд ХАА-н импортын сэлбэг хэрэгсэл, хор бордооны тасалдал хомсдол нь үнийн өсөлтийг бий болгосон.
- Шинжилгээнд тариалалтын талбайн хэмжээ, хүрэлцээ тариалан эрхлэгчдийн өргөжин тэлж өсөхөд сөргөөр нөлөөлсөн нь Орхон аймаг ХАА-н эдэлбэр газрын хэмжээ маш бага, цаашид атаршсан газрыг сэргээх, хөрс хамгаалах технологи нэвтрүүлэх, нэг га-аас авах ургацыг нэмэгдүүлэх, ургамлын сэлгэн тариалалтын технологи нэвтрүүлэх аргуудыг нэвтрүүлэх шаардлагатай байна.
- Корреляцийн шинжилгээгээр сөрөг үзүүлэлтэд “Цагаан тоосны хор уршиг” орсон нь Орхон аймгийн тариалалтын бүс Жаргалант суманд аймгийн нийт тариаланчдын 40.1% нь үйл ажиллагаа явуулдаг. Энэ бүсэд сумын тариаланч ногоочид байршиж ажиллаж амьдардаг нь цагаан тоосноос үүдэлтэй эрүүл мэндээр хохирох асуудал цөөнгүй байна. Нөгөө талаас иргэд, худалдан авагчдын дунд Жаргалант сумаас гаралтай малын мах, хүнсний ногоог авахаас зайлсхийдэг гэсэн аман болон цуу яриа нь борлуулалтад сөрөг нөлөө үзүүлж байна.
- Шинжилгээгээр эерэг нөлөөтэй хүчин зүйлд “Орон нутгийн засаг захиргааны байгууллагын дэмжлэг хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр дүн” орсон нь Орхон аймгаас авч хэрэгжүүлж буй газар тариалангийн салбарт оруулсан төсөл хөтөлбөр авч хэрэгжүүлж буй бодлого, хөрөнгө

оруулалт нь тариаланчдад маш том дэмжлэг болсон. 2017 оноос хойш хэрэгжүүлсэн “Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн хүлэмжийн ургацын хэмжээ 1 дахин нэмэгдсэн мэдээлэл байна. Аймаг 2022 онд л гэхэд ХАА-н салбарт 1,8 тэрбумын хөрөнгө оруулалт хийсэн байна

- Шинжилгээгээр эерэг нөлөөлөх бусад хүчин зүйлд усалгааны систем, эрдэс бордооны хүрэлцээ, үр тарианы олдоц, борлуулалтын цэг салбарын хүрэлцээ эерэг нөлөө үзүүлсэн байна. Энэ нь Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 80% -ийн хямдралтай үр худалдан авдаг бол худаг ус усалгааны системийн өнөөгийн байдал тариаланчид боломжийн үнэлгээ өгсөн харагдаж байна.
- Тариаланчид бүтээгдэхүүн борлуулахад 108,713 иргэдтэй, 29.074 өрхтэй, хүн амын нягтаршил ихтэй, иргэдийн худалдан авах чадвар сайн, томоохон худалдааны цэг салбар супермаркет, хүнсний зах ихтэй, хүнсний бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн багтаамжтай, тээврийн зардал бага өөрийн орон нутагт борлуулалт хийхэд өнөөгийн нөхцөл таатай гэж үзсэн байна.

Санал, зөвлөмж

Монгол улсын Засгийн газраас эх орныхоо хэрэгцээт буудай төмс, хүнсний ногоог дотооддоо үйлдвэрлэх, хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын маш олон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал,

- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, УИХ-ын 2015.11.26, №104
- Алсын хараа 2050, УИХ-ын 2020.05.13, №52
- 2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- “Жимс, жимсгэнэ” Үндэсний хөтөлбөр, 2017-2022
- “Хүнсний ногоо” Үндэсний хөтөлбөр, 2017-2022
- Цөлжилтөөс сэргийлэх, газрын доройтлыг бууруулах Үндэсний хөтөлбөр
- Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян, 2020-2025

Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтууд нь яг малчин, тариаланчдад хүрч байна уу гэдэгт цаашид маш хатуу хяналт тавь ажиллах шаардлагатай байна.

Судалгааны үр дүнд дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

- Өрхийн аж ахуйн чадамжийг дээшлүүлэх,
- Урт хугацаатай эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн нөхцөлийг бий болгох,
- Өрхийн тариаланчдын техник тоног төхөөрөмжийн чадавх муу байгаа тул урт хугацаатай хөнгөлөлтэй зээлийн санхүүжилтээр шийдэх,
- Зоорины хүрэлцээг шийдэх,
- Ногоочдын худаг ус, усалгааны системийг сайжруулах,
- Борлуулалтын тогтмол нийлүүлэгчдийн сувгийг бий болгож тариаланч, борлуулагчдын хоорондын уялдаа холбоог хангаж өгөх,
- Ногоочдын ХАА-н техник тоног төхөөрөмжийн чадамжийг сайжруулах үүднээс хөнгөлөлтэй зээлийн санхүүжилтийн төсөл хөтөлбөрөөр шийдэх,

ХАА-н салбарын өнөөгийн байдалд тулгуурлан шинэчлэл хийх:

- Гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс үүсэлтэй тариалалт, ургац хураалтын эрсдэлийг бууруулах, түлш шатахууныг, тариалалт хураалтын үед нөөцлөх,
- Гадаад эрсдэлээс сэргийлэх үүднээс үрийн фонд байгуулах дэмжлэг үзүүлэх,
- Хөрсийг сэргээх хөрсний шимт тэжээллэг чанарыг бий болгох үүднээс цулгуй уриншийн оронд буурцагт ургамал тариалах, буурцагт ургамал нь уураг ихээр агуулдаг тул хонь үхэр гахай тахианы аж ахуйд ихээр хэрэглэгдэнэ,
- Тариаланчдад хөрс хамгаалах чиглэлээр үр тарианы аж ахуй нэгжүүдэд сүрлэн хучлага технологийг иж бүрэн нэвтрүүлэх,
- Орхон аймагт эрчимжүүлсэн мал аж ахуй хөгжсөнөөр тариаланчид малын тэжээл тариалах сонирхол нэмэгдэнэ.

Ашигласан материал

Б.Энх-Амгалан. (2018 он). *EVIIEWS 9* програмыг шинжилгээнд ашиглах нь. Улаанбаатар.

Мартинес, М. Х. (2014). *Кронбах альфа коэффициент*. Мадрид: Мадрид холбоо.

Үндэсний статистикийн хороо. (2023). *Хөдөө аж ахуй*. 1212.mn

Хүнс, хөдөө аж ахуйн яам. (2023). *Газар тариалан*. www.mofa.gov.mn.

Алтанцэцэг, Одончимэг.Б. (2016). *Хөдөө аж ахуйн салбарын нягтлан бодох бүртгэл*, Улаанбаатар.